

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн товч танилцуулга	2
Ил уурхайн ашиглалтын систем.....	4
Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	5
Техник хэрэгсэл, баяжуулах хэсэг	6
1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	8
1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	10
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	10
2.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
2.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох.....	16
2.6 Түүх, соёлын өвийг хамгаалах	16
2.5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	17
2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	22
2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	25

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-021071 тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд.

Төслийн нэр: “Цагаан тохой” алтны шороон ордыг ашиглах төсөл

Төслийн дугаар: 2019/Т-167

Төсөл хэрэгжүүлэгч: “Бэрлэгмайнинг” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019004047, Регистрийн дугаар: 5007127


Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Тээвэрчдийн гудамж

Төслийн байршил: Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос зүүн хойш 250км, Дархан-Уул аймгаас зүүн урагш 170км, Зүүнхараагаас зүүн хойш 70км –т Бэрлэгийн цагаан тохойд оршино. Тус талбай нь Монгол орны байрзүйн зургийн М-48-107 –р хавтгайд байрлана.

Хүснэгт 1. MV-021071 тусгай зөвшөөрөлтэй 36.22 га талбайн

солбилцол

№	Өргөрөг	Уртраг
1	49° 8' 11.91"	107° 4' 06.32"
2	49° 8' 00.74"	107° 4' 06.32"
3	49° 7' 35.86"	107° 3' 41.31"
4	49° 8' 07.00"	107° 3' 41.31"
5	49° 8' 06.70"	107° 3' 42.08"
6	49° 8' 06.85"	107° 3' 44.02"
7	49° 8' 08.10"	107° 3' 44.06"
8	49° 8' 09.72"	107° 3' 44.13"
9	49° 8' 11.37"	107° 3' 42.55"
10	49° 8' 11.91"	107° 3' 41.77"



Зураг 1. Талбайн байршил

Ордын нөөцийн тооцоо

MV-021071 талбайд В зэрэглэлээр шлихээр 53.84кг, химийн цэврээр 49.0кг, С зэрэглэлээр шлихээр 5.72кг, химийн цэврээр 5.21кг, ВС зэргээр 54.21 кг.

Элс олборлох хүчин чадал.

Ордын нөөц тооцоологдсон блокуудын алттай элсний зузаан нь 1.1-1.44м, хөрсний зузаан нь 8.9-10.2м тус тус байгаа нь ордыг ил аргаар ашиглахад тохиромжтойг харуулж байна.

Хүснэгт 2. Жил бүрийн олборлолт

		Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	Нийт
Хөрс хуулалт	Шимт хөрс	мян.м ³	21.5	14	35.5
	Үндсэн хөрс	мян.м ³	375.11	248.85	623.96
Нийт хөрс		мян.м ³	396.61	262.85	659.46
Элс олборлолт		мян.м ³	50.23	40.77	91
Хөрс хуулалтын коэффициент			7.90	6.45	7.25
Дундаж агуулга		мг/м ³	639.66	669.61	653.08
Металл /Шлих/		кг	32.13	27.3	59.43
Металл /Хими цэвэр /		кг	29.24	24.84	54.08

Эхний жил :

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөгөөр С-1 блокын баруун хойд ирмэгээс эхлэн нээж уулын ажлыг баруун урагшаа ахилт хийн В-2 блокын хилд тулган явуулна.

Хоёр дахь жил :

В-3 блокоос үргэлжлүүлэн В-4,С-2 блокуудыг дуустал ил уурхайн хүрээнд доторх элсийг олборлон дуусгана.

Эхний жилд олборлолттой зэрэгцэн техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж явагдана. 2-дахь жилд мөн олборлолттой зэрэгцэн техникийн нөхөн сэргээлтийн ажил явагдахаас гадна эхний жилд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээх ажил давхар хийгдэнэ. Уулын ажил явагдаж дууссаны дараа биологийн нөхөн сэргээлт, хяналт шинжилгээ, мониторингийн ажил хийгдэнэ.

Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 40.8-50.2 мян.м³ ба угаах төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 40.0 м³/ц болон угаах цехийн цаг ашиглалт 75%-тай ажиллах үед жилд 113-140 хоног ажиллана

Баяжуулах хэсгийн хүчин чадал

Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 40.8-50.2 мян.м³ ба угаах төхөөрөмжийн суурилагдсан хүчин чадал 40.0 м³/ц болон угаах цехийн цаг ашиглалт 75%-тай ажиллах үед жилд 113-140 хоног ажиллана.

Ил уурхайн ашиглалтын систем

Хөрсийг бульдозер, экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэн гадаад түр болон дотоод овоолгод байршуулах, хөрс болон алттай элсний давхаргыг экскаватор автосамосвалын хослолоор тээвэрлэн баяжмалын овоолго, хөрсний гадаад түр болон дотоод овоолгод байршуулна

Хүснэгт 3. Ордыг ашиглах технологи

Технологи	Систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил уурхайгаар ашиглах	Авто тээвэртэй ашиглалтын систем	Хөрс хуулалт	Бульдозероор түрэх
			Өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэх
			Ухаж ачих
			Тээвэрлэх
			Гадаад овоолго
			Дотоод овоолго
		Элс олборлолт	Өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэх
			Ухаж ачих
			Тээвэрлэх

Ордын хуулах хөрсний зузаан нь бохирдол тооцсоноор дунджаар 9.23м, элсний зузаан нь дунджаар 1.42м байна. Тус ордын хөрсний чулуулаг нь элсэн чулуу нь зөөлөн хөрстэй тул доголын налуугийн өнцгийг 55⁰ байхаар сонгож авлаа.

Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд:

- | | |
|---------------------------------|-------------|
| ➤ Ажлын доголын хажуугийн өнцөг | 55 градус |
| ➤ Уурхайн замын өргөн | 10.8 м |
| ➤ Замын налуу | 80 промил |
| ➤ Ажлын доголын өндөр | 5.0 м |
| ➤ Орлын өргөн | 16.2-18.36м |

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ордыг нээх ба ашиглах дараалал

Бэлтгэл ажлын хүрээнд ил уурхайн зам талбай, шимт хөрс хуулах, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах зэрэг ажил хийгдэнэ.

Орд нь олборлоход харьцангуй хялбар, нөөцийн хэсэглэлүүдийн хүрээнд хөлдүүс, цэвдэггүй, хөрсний дундаж зузаан нь 9.23м, элсний зузаан 1.42м, хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 6.66 м³/м³ байна. Ордыг нээхэд С-1 блокын баруун хойд ирмэгээс эхлэн нээж уулын ажлыг явуулна. Мөн блокын хувьд үндсэн хөрсийг дотоод овоолго үүсгэн байрлуулах бөгөөд блокын хилийн гадна сийрэгжилт тооцон дотоод овоолгод багтахгүй хөрсийг байршуулна. Блокуудын хувьд шимт хөрс ялган блокын хилийн гадна овоолго үүсгэн, шимт хөрсний овоолгын налууг 35 градусаар тооцон хийнэ.

Хүснэгт 4. Жил бүрийн олборлолт, календарчилсан төлөвлөгөө

		Хэмжих нэгж	1-р жил	2-р жил	Нийт
Хөрс хуулалт	Шимт хөрс	мян.м ³	21.5	14	35.5
	Үндсэн хөрс	мян.м ³	375.11	248.85	623.96
Нийт хөрс		мян.м ³	396.61	262.85	659.46
Элс олборлолт		мян.м ³	50.23	40.77	91
Хөрс хуулалтын коэффициент			7.90	6.45	7.25
Дундаж агуулга		мг/м ³	639.66	669.61	653.08
Металл /Шлих/		кг	32.13	27.3	59.43
Металл /Хими цэвэр /		кг	29.24	24.84	54.08

Эхний жил :

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөгөөр С-1 блокын баруун хойд ирмэгээс эхлэн нээж уулын ажлыг баруун урагшаа ахилт хийн В-2 блокын хилд тулган явуулна.

Хоёр дахь жил :

В-3 блокоос үргэлжлүүлэн В-4,С-2 блокуудыг дуустал ил уурхайн хүрээнд доторх элсийг олборлон дуусгана.

Эхний жилд олборлолттой зэрэгцэн техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж явагдана. 2-дахь жилд мөн олборлолттой зэрэгцэн техникийн нөхөн сэргээлтийн ажил явагдахаас гадна эхний жилд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээх ажил давхар хийгдэнэ. Уулын ажил явагдаж дууссаны дараа биологийн нөхөн сэргээлт, хяналт шинжилгээ, мониторингийн ажил хийгдэнэ.

Ил уурхайн хөрс хуулалт ба овоолгын ажлын төлөвлөгөө

Ил уурхайн хөрс хуулалтын дундаж зузаан бохирдолт тооцсоноор 9.23м байна. Үүнээс шимт хөрс нь 0.46м байх бөгөөд шимт хөрсийн овоолгыг блокын хилийн дагуу 35 градус үүсгэн овоолно.

Хүснэгт 5. Хөрс хуулах болон овоолгын төлөвлөгөө

	1-р жил		2-р жил		Нийт	
	Талбай/га/	Эзэлхүүн/мян.м ³ /	Талбай/га/	Эзэлхүүн/мян.м ³ /	Талбай/га/	Эзэлхүүн/мян.м ³ /
Шимт хөрс	0.98	21.5	0.89	14	1.87	35.5
Үндсэн хөрс	1.74	375.11	/Дотоод/	248.85	1.74	623.96
Нийт	2.72	396.61	0.89	262.85	3.61	659.46

Техник хэрэгсэл, баяжуулах хэсэг

Ил уурхайн тоног төхөөрөмжийн бүрдэл

Төсөл хэрэгжүүлэгч нь өөрт байгаа, урьд нь ашиглагдаж байсан тоног төхөөрөмжүүдийг ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан тооцоог хийлээ.

Хүснэгт 6. Захиалагчид бэлэн байгаа тоног төхөөрөмжийн жагсаалт


№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	тоо
1	Экскаватор	Hyundai 300 LC9	1
3	Бульдозер	LIEBHERR PR742R	1
4	Автосамосвал	Nord Benz 24тн	4
6	Авто ачигч	ZL-50	1

Ил уурхайн үндсэн технологийн процесс нь экскаватороор хөрс хуулалт болон элс олборлолтийг хийн, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг байна. Иймд ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдэд экскаватор, автосамосвал, бульдозер зэргүүдийг тусгалаа.

Элс угаан баяжуулах технологи

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг Д-40 маркийн скруббер 1 ширхэг, гүйцээн баяжуулалтанд баяжуулах ширээ гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихийг ялгаж авна. Угаах төхөөрөмжөөс ялгасан шлихийн баяжмалыг гүйцээн баяжуулах цехэд боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулах ба дараа нь соронзонгоор хар шлихийг ялгаж цахилгаан зуухан дээр хатааж, тороор шигшин ангилж, ангилал бүрийг үлээн ялгана.



Зураг 2. Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн схем

Хүснэгт 7. Элс угаан баяжуулах цехийн ажиллах горим

№	Ажиллах горим	1-р жил	2-р жил	Нийт
1	Жилийн хуанлийн хоногийн тоо	365	365	365
2	Жилийн хуанлийн цаг	8760	8760	8760
3	Хоногийн хуанлийн цаг	24	24	24
4	Цаг ашиглалт, %	75.00	75	75
5	Ээлжинд ажиллах цаг	12	12	12
6	Хоногт ажиллах ээлжийн тоо	1	1	1
7	Жилд ажиллах цаг	2791	2265	2528
8	Жилд ажиллах хоног	140	113	126
9	Цагийн хүчин чадал, м ³ /цаг	40.00	40.00	40.00
10	Хоногийн хүчин чадал, м ³ /хоног	358.7	360.7	366.0
11	Жилийн хүчин чадал, мян.м ³ /жил	50.23	40.77	91

1.2 Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Төслийн талбай нь Монгол орны бусад нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай эрт хүйт орж, цасан бүрхэвч тогтдог, хоногийн болон жилийн температурын амплитуд их, улирлын эрс өөрчлөлттэй нутаг юм.

Уур амьсгалын мужлалаар чийглэг, нэн сэрүүн ба чийглэгдүү, сэрүүн уур амьсгалтай бүсийн нэн хүйтэн бүсэд хамаарна (БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас. 1985). Агаарын жилийн дундаж температур уулархаг газраа -7.1°C бөгөөд хамгийн дулаан үе болох 7-р сард дунджаар $+15+25^{\circ}\text{C}$ байдаг бол өвлийн их хүйтрэлтийн үе 1-р сарын дундаж температур $-30-37^{\circ}\text{C}$ хүрдэг. Жилд унах хур тунадасын хэмжээ 110 мм бөгөөд түүний ихэнхи нь зуны улиралд унадаг. Зуны хамгийн их бороотой үе нь 8 сард байдаг бол цас 9-р сарын 2-р хагасаас орж эхэлдэг. Сүүлийн таван жилийн ажиглалтын мэдээгээр 2016 оны 8 дугаар сард нийлбэр хур тунадас хамгийн их болж 122.6 мм хүрсэн байна.

Талбайн хэмжээнд Өндөрлөгдүү газраар *Сайргархаг Харшороон* хөрс 53.9 га голын хөндий дагаад *Ердийн Харшороон* хөрс 110.3 га, уулын бэлээр *Ойн бараан* хөрс 28.4 га талбайд тархсан байна. Талбайн хэмжээнд одоогоор үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд хөрсний төлөв байдалд өөрчлөлт ороогүй байна.

Талбайн хэмжээнд эвдрэлийн ул мөр бага ажиглагдсан ба талбай нь бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байсан.

Цагаан тохой алтны шороон орд орчмын нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн муж, Дорнод Сибирийн шинэс-нарсан ойн дэд их муж, Хэнтийн уулын тайгын мужид хамаарагдана. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн орчмоор Ерөө голын дагуу татмын улиас - хусан ой хосолсон үетэн - алаг өвст (*Geranium Vlassiovianum*+ *Vicia cracca*+*Filipendula palmata* + *Sanguisorba officinalis*+*Equisetum pratense* +*Agrostis mongolica*+*Poa pratensis*) нугын хэвшинжийн ургамалжил зонхилон тархаж байна. Талбай нь үндсэндээ бэлчээрийн эдэлбэр газар бөгөөд бэлчээрийн ургамалжлын төлөв байдлын хувьд талхагдалд бага зэрэг өртсөн байна

Талбай нь үндсэндээ бэлчээрийн эдэлбэр газар бөгөөд бэлчээрийн ургамалжлын төлөв байдлын хувьд талхагдалд бага зэрэг өртсөн байна. Лицензийн талбай Ерөө голын эрэг дагасан, эргэн тойрон ой бүхий уулсаар хүрээлэгдсэн олон зүйл амьтан идээшлэж, хоргодон нуугдаж, ундаалж, сууршин амьдрах, мөн нутгийн гол төлөв бод малтай цөөн тооны айл өрх суурьшсан нутаг юм.

1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн хэсгүүд	Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөө
Газрын хэвлий	Уурхайн олборлолт явуулж газрын хэвлийн чулуулгийн тогтоц, бүтцэд сөрөг нөлөө үзүүлнэ.

Эдэлбэр газар	Уурхайн барилга байгууламж, олборлолтын үйл ажиллагаагаар бэлчээр хязгаарлагдах, газрын гадаргад эвдрэл үүсэх, газар эзэмших боломжийг хязгаарлах, мал амьтанд аюултай уурхайн малталт үүсэх
Агаар	<ul style="list-style-type: none"> - Уурхайн тээвэр, эвдрэлд орсон зам талбай, бутлуурын үйлдвэрийн үйл ажиллагаа, жонш бутлах ачих, буулгах, овоолгын талбай зэргээс тоосжилт үүсэх. Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед үүссэн тоос агаар орчныг бохирдуулахаас гадна хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ. - Уурхай дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь агаар бохирдуулагч эх үүсвэрүүд болно. Автомашинны түлшний шаталтаас угаарын хий агаар орчныг бохирдуулна. Түлшний эх үүсвэрээс агаарт гарах дэгдэлт нь уурхайн тоног төхөөрөмжийн ажиллагаанаас болон уурхайд ажиллах хүнд механизм, тээврийн машинуудаас, бусад зөөврийн төхөөрөмжүүд (дизель мотор, түр зуурын болон аваарын станцууд зэрэг)-ийн ажиллагаанаас үүсэлтэй байна.
Ус	<ul style="list-style-type: none"> - Гадаргын усны голидрол өөрчлөгдөх, тэжээгдэл багасах - Усны нөөц багасах, чанарт өөрчлөлт орох - Гүний усны нөөц горим алдагдах, чанар өөрчлөгдөх - Ахуйн бохир усыг зөв зохицуулаагүйгээс үүдэн хөрс, усны бохирдолт үүсэх
Хөрс	<ul style="list-style-type: none"> - Уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулах талбайн хөрсөн бүрхэвч хуулагдаж үржил шим, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөнө. - Уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэлх дотоод замын хөрс хуулагдаж үржил шим, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөнө. - Ахуйн хог хаягдал болон машин техникийн засварын үйл ажиллагаанаас хөрсний бохирдол хязгаарлагдмал орчинд үүснэ. - Ажилчдын кемп, баяжуулах үйлдвэр, хөрсний овоолго зэрэгт өртсөн талбайн хөрс элэгдэл эвдрэлд орно. - Хүн, машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарч, шороо суларч, элэгдэл эвдрэлд өртөх талбайн хэмжээ нэмэгдэж болзошгүй. Бензин, тос, дизелийн асгаралт, шүүрэлт мөн үйлдвэрлэлийн болон, ахуйн хэрэглээний хог хаягдлаас хөрсний бохирдол үүснэ.
Ургамал	<ul style="list-style-type: none"> - Уурхайн олборлолт хийх талбай болон баяжуулах үйлдвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлаас үүдэн бэлчээрийн ургамлын биомасс устаж талхлагдана. - Хөрс хуулалт (овоолго) дотоод, гадаад тээвэрлэлт, барилга байгууламжийн угсралт зэргээс үүдэн ургамал ургалтанд сөрөг нөлөө үзүүлнэ.
Амьтны аймаг	<ul style="list-style-type: none"> - Машин техник хэрэгслийн дуу чимээ, шатах тослох материалын үнэр зэргээс зэрлэг туурайтан амьтны амьдрах орчин өөрчлөгдөх (дайжих), устах зэрэг - Уурхайн талбайд хөрс хуулах явцад шавьж болон нүхэнд амьдардаг амьтад устах - Амьтны аймгийн байршил, зүйлийн бүрдэл, зан төлөвт өөрчлөлт орох магадлалтай.
Түүх соёлын өв	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх соёлын үнэт зүйлс бүртгэгдээгүй.
ТХГН	Төслийн талбайтай давхцалтай болон хил залгаа ТХГН байхгүй.

БҮЛЭГ II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Уурхайн барилга байгууламж барих, олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР						
Тоосжилт үүсэх	Уурхайн дотоод замыг услаж тоосжилтыг багасгах	Уурхай доторх зам	Хоногт 1 удаа	Усны зардалд тусгагдсан		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль;
Утаа болон хийн бохирдол үүсэх	Машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, шаардлагатай тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх төхөөрөмж тавих	Уурхайн машинууд	1-2 улирал	Сэлбэг материалын зардалд тусгагдсан		Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009
	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд даацын машин механизм болон суудлын машин техник		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Дизель хөдөлгүүртэй авто машин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС						
Усны нөөц багасах, түвшин буурах	Уурхай, засварын газар, хог хаягдал түр хадгалах цэгийн эргэн тойронд үерийн шуудуу ухах	Үерийн ус орохоос сэргийлэх, уурхайн далан сэтгэрч эргэлтийн ус алдагдахаас хамгаалах	6 сар	-		Монгол Улсын стандарт (MNS 4943-2011), Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.
	Усны нөөц хомсдохоос сэргийлж усны тоолуурыг баталгаажуулах	Гадаргын болон гүний ус	Баяжуулалт эхлэхээс өмнө	0.15		Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	Ерөө голоос ус татах хэсэгт тоолуур суурилуулах	Ус татах хоолой	Уурхайн олборлолт эхлэхээс өмнө	0.2		“Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
	Ус татах хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж	Ус татах хоолойн дагуу	Тогтмол	-		

	хоолой цоорсон, ус алдагдсан тохиолдолд засварлах					
Гүний уны бохирдол	Шатах тослох материал түгээх цэг, хог хаягдлын талбай, засварын газрын талбайн доорх хэсгийг хатуу хучилттай болгох	Хөрс бохирдох	4 сар		0.4	
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ						
Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол бий болох	Уурхайн дотор болон гадаад зам дагуу хурдны хязгаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Уурхайн талбайд болон сумаас ирэх зам дагуу	5 сар	-	0.3	Газар шорооны ажлын үед үржил, шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэсэн газрын нөхөн сэргээлт: Техникийн ерөнхий шаардлага MNS 5917 : 2008 Газрын тухай хууль: 56.6 дугаар зүйл. газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана. MNS 5958:2018
	Уурхайн ажилчдын хотхон болон боломжтой хэсгүүдэд мод тарьж, ногоон байгууламж бий болгох, цэцэрлэгжүүлэх	Зүлэг, цэцэг, модлог ургамал тарих	Хавар, намар		0.5	
	Ажилчдын байр, 00 өрөө, хоолны газруудад ариутгал, халдваргүйтгэл хийх	Хөрс, хүний эрүүл мэнд	7 хоног тутамд		0.2	
	Ажилчдад “MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” хангасан нүхэн жорлон байгуулах	Хөрс улмаар газрын доорхи ус бохирдох	Уурхай эхлэхэд		2.0	
4. АМЬТНЫ АЙМАГ						
Амьтанд гэмтэл учруулах,	Хөхтөн амьтан түгээмэл тархдаг, бэлчдэг хэсгүүдэд өвс, хужир тараах зэргээр сумын байгаль орчны				1.0	

тоо толгой хорогдох	байцаагтай хамтран биотехникийн арга хэмжээ авах					
	Эргэлтийн усан санг тойруулан шуудуу татах эсвэл хашаалж мал, амьтан унахаас сэргийлэх	Эргэлтийн усан сан	5 сар	-	0.3	
	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	Нийт ажилчид	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-	
Нийт зардал, мян.төг					5.05	

2.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

2023 онд MV-021071 тусгай зөвшөөрөлтэй “Цагаан тохой” алтны шороон орд ашиглах төслийн хүрээнд 6.8 га талбайд биологийн нөхөн сэргээлт, 3.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт (2.4 га-д гадаад овоолго, 1.5 га-д дотоод овоолгоор) хийхээр төлөвлөлөө.

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн олборлолтонд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Нөхөн дүүргэх, түрж тэгшлэн хэлбэршүүлэх	га	3.9 (2.4-гадаад овоолго, 1.5-дотоод)	Дотоод овоолгоор хийгдэнэ.		2-3 улиралд	MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
2	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийнэ.	Хус, шинэс, бургас, улиас бүхий мод тариалах	га	6.8	Уурхайн дотоод зардалд тусгагдсан.		2, 3-р улиралд	

Агротехнологийн карт

Батлав:		Биологийн нөхөн сэргээлтийн чиглэл: Хөдөө аж ахуй – бэлчээр, газар тариалан	
Сэлэнгэ аймгийн Ерөө суманд орших эвдэрсэн газрыг нөхөн сэргээх агротехнологийн карт, 2023 он			
Нийт ажлын хэмжээ	Орон нутгийн онцлог	Тарих ургамлын үрийн норм	Агротехнологи
Нийт талбай, га: 6.8 Үүнээс: Хэлбэршүүлэх, га: 6.8 Гараар сэргээх, га: 0 Ургамалжуулах, га: 6.8	Байгалийн бүс: хээрийн Жилийн тунадас, мм: 260-300 Шимт хөрсний зузаан, метрээр: 0.4 Хөрсний ялзмагийн хэмжээ: 1.05 %	Олон наст үет ургамлын үр, кг/га: 45-55 Олон наст буурцагт ургамлын үр, кг/га: 45-55 Нэг наст нөмрөг ургамлын үр, кг/га: 20	Agriplant бордоо: 20гр/100л Усалгааны норм, м ³ /га: 40

Тарих норм,

№	Нөхөн сэргээлт хийх ургамал	3 га-д шаардагдах үр болон тарьцын хэмжээ	Нөхөн сэргээлт хийх талбай га	Суулгац болон үрийн хэмжээ
1	Модлог ургамал	Хус, улиас эгнээ хооронд 4м, мод хооронд 4м, 1 га 800 ш	1	800 ш
2	Олон наст	Ерхөг согоовор	3.8	190 кг

2.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2021 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төслийн ерөнхий үнэлгээнд заагдсан чиглэлийн дагуу орон нутгаас санал болгосон газар болох Ялбагийн хөндийн доод хэсэгт 3 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийн Мэргэжлийн хяналтад хүлээлгэн өгсөн.

Төслийн БОННУ-нд тусгагдсан зардал, талбайн хүрээнд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хийж гүйцэтгэсэн тул дахин дүйцүүлэн хамгааллын ажил төлөвлөөгүй болно.

2.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь уурхайлалтанд өртөөд удаж байгаа тул ойролцоо айл, өрх, өвөлжөө, хаваржаа байхгүй. Иймээс нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох шаардлага гарахгүй.

2.6 Түүх, соёлын өвийг хамгаалах

Судалгааны талбайд түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй боловч газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалын задаргаа

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Мониторинг	Биелэлтийн шалгуур	Хэрэгжилтэд хяналт тавих
Биотехникийн арга хэмжээ авах	Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүнд зэрлэг амьтдад жил бүрийн өвөл, хаврын улиралд орон нутаг болон мэргэжлийн байгууллагатай хамтран өвс тэжээл, хужир мараа, мөс (жилийн бүрийн өвөл, хаврын улиралд 100 боодол өвс, 50 кг давс) тавьж өгөх.	-	0.75	Жил бүрийн өвлийн улиралд	Ан амьтдын тооллого хийж, сүргийн бодгалийн хүйс, үр төлийн тоо мэдээллийг ялган тэмдэглэх зэргээр мониторинг хийх	Зэрлэг амьтдын бодгалийн өсөлтийн тоо хэмжээ	Орон нутгийн удирдлага
Зэрлэг амьтдын мониторингийн судалгаа хийх	Зэрлэг амьтдын мониторингийн судалгаанд дэмжлэг үзүүлэх: Үүнд зэрлэг амьтдын нарны зайгаар ажиллах байршил тогтоогч хүзүүвчээр хангах (5 ш*300.0 мян.төг = .0 сая.төг).	-	0.75	2023			
Орхигдсон газар нөхөн сэргээх	Уурхайн ойролцоох орхигдсон 3 га талбайд хөрс сайжруулах, модлог болон олон наст тарих, усалгаа арьчилгаа хийх	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	2023	-	Нөхөн сэргээлтийн үр дүн	
Нийт дүн			1.5				

2.5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр гарч байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хохирол учруулах	Гал түймэр, үер, байгалийн аюул үзэгдэл, гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	Жилд 1 удаа	300.0	300.0	Уурхай эхлэх үед	Гамшгаас хамгаалах тухай хууль
2		Ажилчдын байр, гал тогоо зэрэг газруудад галын дохиоллын систем суурилуулах	Шаардлагатай газруудад	2	35.0	70.0	2-р улирал	М85078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага”
3		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Ажилчдын байр, гал тогоо, цайны газар, гадаа	4	55.0	220.0	Уурхай эхлэх үед	
4		Ажилчдын байранд аюулын гарц заасан самбар байршуулах	Ажилчдын байрны коридор, гал тогоо, цайны газар	3	-	-	Уурхай эхлэх үед	5390:2004, “ХААЭА. Цахилгааныг ажлын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
5	Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Галын аюул гарч болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	ШТС, гал тогоо	2	-	-	Уурхай эхлэх үед	
6		Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдал хяналт тавих, доорх талбайг цементлэн хатуу хучилттай болгож шатах тослох материал хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлэх	Шатахууны агуулахын доорх талбай	25м ²	дотоод	150.0	2-р улирал	MNS 5850:2018

7		Шаардлагатай газруудад аянга зайлуулагчийг байрлуулах	аянга зайлуулагч	1	200.0	200.0	
8	Шаардлагатай хувцас, хэрэгслээр хангаагүйгээс ажилчдын эрүүл мэнд, амь насанд эрсдэл учрах	Ажилчдыг ажлын байрны онцлогт тохирсон хувцас, хөөдлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Уурхайн бүх ажилчид		Дотоод төлөвлөгөөнд тусгагдсан		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 4969:2000
9	Нийт зардал, мян.төг				920.0		

2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Хэлбэр	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Ахуйн	Хатуу	Шил, лааз, хуванцар сав, хоолны үлдэгдэл, батерей, дугуй, төмөр, модны хаягдал гэх мэтээр хог хаягдлыг ангилан ялгаж уурхайн хог хаягдал хадгалах цэгт түр хадгалах, 2-догч түүхий эд авах цэгт нийлүүлэх	2-догч түүхий эд авах цэгт нийлүүлэх	-	-	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
			Үлдсэн ахуйн аюултай бус хог хаягдлыг Ерөө сумын ТҮК-ээр зайлуулах	Хог хаягдлаар хөрс бохирдох	-	Гэрээний дагуу	Сард 2 удаа	14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тэвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ
		Хоол хүнс	Хоол хүнсний хаягдлыг бокаши бордоо болгох	Хөрс бохирдох	-	225.0	7 хоногт 1 удаа	
			Ажилчдын байр, оффис, гал тогоо, засварын газар зэрэг газруудад хог хаягдал ангилан ялгах зорилуулалт бүхий хогийн сав байрлуулах	Ангилан ялгаагүйгээс холилдон дахин ашиглах боломжтой хог хаягдал хаягдах	12	360.0	2-р улирал	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;

2	Аюултай	Шингэн	Ажилласан шатах тослох материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан Хай би ойл ХХК, Монпиги ойл ХХК, Ахуй мандал ХХК гэх мэт аюултай хаягдал тос боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	хуримтлуулсаныг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	-	600.0	Жилд 1 удаа шаардлагатай тохиолдолд тухай бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5.үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
		хагуу	Ашиглалтаас гарсан дугуйг Инахис ХХК, хаягдал батерейг Цэнгэг усны төв, аккумуляторыг хаягдал аккумулятор боловсруулах зөвшөөрөлтэй үйлдвэрт нийлүүлэх	Хөрс, газрын доорхи ус	-	-		
Нийт						1185.0		

2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал мян.төг	Зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1. АГААРЫН ЧАНАР					
Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос PM _{2.5} , PM ₁₀ Тоосны уналт Бохирдлын цэгэн эх үүсвэр: SO _x , NO _x	- Олборлолт явуулж буй талбай, талбайгаас доош 300м зайд - Ажилчдын байр - Хөрсний овоолгын салхины чиглэлийн доор, 300м зайд	<ul style="list-style-type: none"> Жилд 2 удаа 5, 11-р сард 	50.0*5*2	500.0	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007 MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох Дэлхийн банк. Төрөл бүрийн ажлын орчин дахь дуу шуугианы хязгаарлалтууд, 2007.04.30
Орчны дуу чимээ	- Уурхайн олборлолтын талбай болон баяжуулах төхөөрөмж - Ажилчдын амрах байр	Дотоод тээвэрлэлт болон бусад шуугианы эх үүсвэр дээр, стандартаас давсан тохиолдолд бууруулах арга хэмжээ авах			
2. ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УС					
Усны ерөнхий химийн шинжилгээ, рН, TDS (нийт ууссан давс), нийт хатуулаг (CaCO ₃), ууссан хүчилтөрөгч, BXX, XXX, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ ны агууламж, амт, үнэр, өнгө.	- Уурхайн унд ахуйн усны эх үүсвэр болох худаг - Эргэлтийн усан сан - Ерөө гол	Жилд 2 удаа 5, 8 сард*3 байршилд	Усны ерөнхий химийн шинжилгээ 46.0	606.0	Усны тухай хууль 2012.05.17 Ундны усны чанарын стандарт MNS 900:2018
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ					

Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн, хүнд металл, эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	1. Шимт хөрсний овоолго 2. ШТС 3. Хогийн цэг 4. Ажилчдын байрны ойролцоо 5. Засварын талбай	Жилд 2 удаа (хавар, намар)*5 байршилд	Химийн шинжилгээ - 20.0 Хүнд металл 30.0< Эрүүл ахуй 20.0	700.0	“Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 Дээжлэлт хийхдээ MNS:3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
4. АМЬТНЫ АЙМАГ					
Туруутан амьтдын тоо, толгой шилжилт хөдөлгөөнийг тогтоох, тандалт хийх Шувуудын зүйлийн бүрдэл болон нягтшил, амьдрах орчны тандалт судалгааг хийх	Төслийн талбай орчимд болон ойр орчмын өндөрлөг цэгүүдэд	Орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран тооллого ажлыг хамтран хийх жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаар		Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй
5. УРГАМЛАН НӨМРӨГ					
Уурхай талбай болон нөлөөллийн бүсэд ургамлан нөмрөгийн судалгаа хийх	Шимт хөрсний овоолго, нөхөн сэргээсэн талбай, нөлөөлөлд өртсөн талбай	Уурхайн байгаль орчны мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар		
2023 орчны хяналт шинжилгээний зардал, мян.төг				1806.0	

2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж БОАЖЯ-аар батлуулах	-	1 улирал	Захирал	БОНБУ-ий тухай хууль, БОАЖС-ын А/618 тушаал
2	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Сээнгэ аймгийн БОГ-т тайлагнах	-	11 сарын 1	Захирал, мэргэжлийн боловсон хүчин эсвэл мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	БОНБУ-ий тухай хууль
3	Усны газраар “Ус ашиглуулах дүгнэлт” гаргуулах	50.0	1 улирал	Менежер	Усны тухай хуулийн 28 дугаар зүйл
4	Ерөө голын сав газрын захиргаанаас “Ус ашиглах зөвшөөрөл” авч “Ус ашиглах гэрээ” байгуулах	50.0	1 улирал	Захирал	Усны тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл
5	Ерөө голын сав газрын захиргаагаар ус ашиглах эрхийн бичиг сунгуулах	-	1 улирал	Захирал	Усны тухай хуулийн 28 дугаар зүйл
6	Ерөө голын сав газраас хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авч гэрээ байгуулах	50.0	1-2-р улирал	Захирал, Менежер	Усны тухай хууль
7	Нийгмийн хариуцлагын хүрээнд Ерөө сумын Засаг даргатай харилцан тохиролцсоны дагуу сумын спорт цогцолборын фитнес төвийг тоног төхөөрөмжөөр хангах	Дотоод зардлаар	3-4 улирал	Захирал	Нийгмийн хариуцлагын гэрээ
8	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Аймгийн БОАЖГ-аас зааж өгсөн газарт мод тариалах, арчлах, ургуулах				
	Нийт зардал, мян.төг	150.0			

2.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	<p>“Бэрлэгмайнинг” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн</p> <ul style="list-style-type: none"> Сэлэнгэ аймгийн Ерөө сумын (багийн иргэд) Багийн дарга сумын байгаль хамгаалагч 	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээ хийсэн талаар (ppt) танилцуулна хийнэ.	2023 онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар болон хяналт мониторинг хийсэн тухай, орон нутагтай хамтран ажиллсан тухай	2023 оны 10-11 сар	бензин 150.0, оролцогчдод гарын авлага тараах 50.0,	“Бэрлэг майнинг” ХХК-ийн Байгал орчны мэргэжилтэн	Багийн төвд
Нийт зардал мян.төг					200.0		

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 9.31 сая.төг зарцуулахаар байна. Үүнд

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ - 5.05 сая.төг
- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө - 920.0 мян.төг
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө - 1.185 сая.төг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр - 1.806 сая.төг
- Удирдлага, зохион байгуулалтын хэрэгжүүлэх арга хэмжээ – 150.0 мян.төг
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах - 200.0 мян.төг

